

Боловсролын сайдын  
2024 оны 09 дүгээр сарын 19 ны өдрийн  
1/95 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ, УДИРДАХ АЖИЛТАНД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг зүйл

1.1. Хүүхдийн цэцэрлэгийн (цаашид “цэцэрлэг” гэх) багш, арга зүйч, эрхлэгчид мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгохтой холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Мэргэшлийн зэргийг энэхүү журамд заасан ерөнхий болон тусгай шалгуурыг хангасан, цэцэрлэгт ажиллаж байгаа багш, арга зүйч, эрхлэгчид тус тус олгоно.

1.3. Мэргэшлийн зэрэг нь багш, арга зүйч, эрхлэгчийн мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

1.4. Мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагаанд багш, удирдах ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан, ил тод, нээлттэй, мэргэжлийн үнэ цэнэ, нэр хүндийг эрхэмлэсэн, аливаа хөндлөнгийн нөлөөлөл, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална.

1.5. Мэргэшлийн зэрэг нь өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгт нэгэн адил хүчинтэй байна.

### Хоёр. Мэргэшлийн зэргийн шатлал, хүчинтэй хугацаа, үйлчлэх хүрээ

2.1. Цэцэрлэгийн багш, арга зүйч, эрхлэгчид олгох мэргэшлийн зэрэг нь:

2.1.1. Заах аргач;

2.1.2. Тэргүүлэх;

2.1.3. Зөвлөх гэсэн шатлалтай байна.

2.2. “Заах аргач” мэргэшлийн зэргийг мэргэжлээрээ 3 жил ажилласан багшид олгоно.

2.3. Мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаа шатлал бүрд 5 жил байна

2.4. Мэргэшлийн зэргийг анх олгосноос хойш 5 жил тутамд бататгах бөгөөд шалгуурыг хангаагүй тохиолдолд хүчингүйд тооцно.

2.5. Мэргэшлийн зэргийг хугацаанд нь бататгаагүй тохиолдолд хүчингүйд тооцно.

2.6. Энэ журмын 6.3-т заасан үндэслэлээр мэргэшлийн зэргийн хүчингүй байх хугацаа нь 1 жил байна.

2.7. Мэргэшлийн зэргийг шатлал алгасаж олгохгүй.

2.8. Мэргэшлийн зэрэг олгосныг нотлох баримт бичиг нь мэргэшлийн зэрэг олгосон эрх бүхий албан тушаалтны шийдвэр байна.

2.9. Мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох чиг үүргийг доор дурдсан байгууллага хэрэгжүүлнэ.

2.9.1. “Заах аргач” мэргэшлийн зэргийг тухайн цэцэрлэг, “Тэргүүлэх” мэргэшлийн зэргийг Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, “Зөвлөх” мэргэшлийн зэргийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус олгоно.

2.10. “Заах аргач” мэргэшлийн зэрэгтэй багш нь мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан, энэхүү журамд заасан ерөнхий болон тусгай шалгуурыг хангасан, хамт олон, эцэг эх асран хамгаалагчтай хамтран ажиллах, мэргэжлийн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх болон ёс зүй, харилцаа хандлагаараа манлайлан ажиллах чадвартай байна.

2.11. “Тэргүүлэх” мэргэшлийн зэрэгтэй багш нь “Заах аргач” зэрэгтэй, энэхүү журамд заасан шалгуурыг хангасан байгууллагын болон орон нутгийн түвшинд мэргэжлийн багш нарын бүлгийг чиглүүлэн ажиллаж, зөвлөгөө дэмжлэг үзүүлж, боловсролын сургалтын байгууллага, багшийн хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллах чадвартай байна.

2.12. “Зөвлөх” мэргэшлийн зэрэгтэй багш нь “Тэргүүлэх” мэргэшлийн зэрэгтэйгээр 5 жил ажилласан, энэхүү журамд заасан шалгуурыг хангасан, үндэсний болон орон нутгийн түвшинд байгууллага, мэргэжлийн багш нарын бүлгийг удирдан чиглүүлж, зөвлөх чадвартай, багаар хамтран ажиллах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, боловсролын сургалтын байгууллага, багшийн хөгжилд хувь нэмрээ оруулах чадвартай байна.

2.13. Энэ журмын 1.7-д заасан дагуу хугацаанаас өмнө дараах тохиолдолд мэргэшлийн зэрэг олгож болно.

2.13.1. Орон нутаг, үндэсний түвшинд мэргэжлийн багш нарын бүлгийг удирдан чиглүүлж, үр дүнд хүрсэн;

2.13.2. Орон нутаг, үндэсний түвшинд шинэлэг сургалтын арга зүйг, туршин хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн;

2.13.3. Үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнд илтгэл хэлэлцүүлж, (тухайн илтгэл нийтлэгдсэн байх);

2.13.4. Багшийн хөгжлийн үндэсний төвийн арга зүйн сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн тохиолдолд “Заах аргач” мэргэшлийн зэрэг;

2.13.5. Багшийн хөгжлийн үндэсний төвийн арга зүйн сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн бөгөөд орон нутаг, бүс, үндэсний түвшинд багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг хамтран зохион байгуулсан тохиолдолд “Тэргүүлэх” мэргэшлийн зэрэг;

2.14. Боловсролын ерөнхий хуулийн 12.14, Хөдөлмөрийн тухай хуулийн 59 дэх зүйлийн дагуу аймаг, сум, дүүрэг, баг, тосгоны хүүхдийн цэцэрлэгт боловсролын сургалтын байгууллагын адил чанарын өөр ажилд шилжин ажилласан тохиолдолд мэргэшлийн зэргийг бататгах, ахиулах хугацаа нь 3.5 жил байж болно.

### **Гурав. Мэргэшлийн зэргийн шалгуур**

3.1. Мэргэшлийн зэрэг олгоход дараах ерөнхий шалгуурыг баримтална.



- 3.1.1. Хариуцсан бүлэг/цэцэрлэгийн хүүхдийн эзэмшсэн чадварт ахиц гарсан байх;
- 3.1.2. Багшийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, мэргэжлийн багш нартай бүтээлчээр хамтран ажиллах ур чадвар эзэмшиж, тодорхой үр дүнд хүрсэн байх;
- 3.1.3. Багш, удирдах ажилтны мэргэжлийн нэр хүнд, ёс зүйг эрхэмлэн, ёс зүйн зөрчилгүй байх;
- 3.1.4. Мэргэшлийн зэрэг олгох эсвэл сунгахыг багш нарын зөвлөлийн хуралд оролцогчдын 90-ээс доошгүй хувь нь дэмжсэн байх;
- 3.2. Ерөнхий шалгуурыг хангасан багш, арга зүйч, эрхлэгчийн албан тушаалын чиг үүргийн онцлогоос хамаарч энэ журмын 3.2.1, 3.2.2, 3.2.3-д заасан тусгай шалгуурыг баримтлан мэргэшлийн зэрэг олгож, бататгана.

3.2.1. Багшид мэргэшлийн зэрэг олгох тусгай шалгуур:

Тусгай шалгуур	Мэргэшлийн зэрэг		
	Заах аргач	Тэргүүлэх	Зөвлөх
Хүүхдийн хөгжлийн ахиц	-Хүүхэд бүрийн хөгжилд гарсан ахиц, өөрчлөлтийг тооцож, хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнд суурилсан хувилбарт арга зүйг боловсруулсан байх; -Хүүхдийн эзэмшвэл зохих чадварт ахиц гарсан байх;		-Хүүхэд бүрийн хөгжилд гарсан ахиц, өөрчлөлтийг тооцож, хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнд суурилсан хувилбарт арга зүйг боловсруулан, хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн байх; -Хүүхдийн эзэмшвэл зохих чадварт ахиц гарсан байх;
	-Сургалт, үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулах бүтээлч арга зүйг хэрэгжүүлэн, үр дүнг тооцсон байх;	-Сургалт, үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулах 2-оос доошгүй бүтээлч арга зүйг эзэмшсэн байх	-Сургалт, үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулах 3-аас доошгүй арга зүйг эзэмшиж, бүтээлчээр ашигладаг байх
Багшийн мэргэжлийн хөгжил,	-Багшийн хувийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх;  -Ажлын байранд мэргэжил, арга зүй, ур чадвараа тасралтгүй	-Багшийн хувийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх;  -Ажлын байранд мэргэжил, арга зүй, ур чадвараа тасралтгүй	-Багшийн хувийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, үр дүнд тооцсон байх;  -Ажлын байрандаа мэргэжил, арга зүй, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэн, шинэлэг санаа, бүтээлч арга зүй, дэвшилтэт технологийг хэрэгжүүлэн түгээн дэлгэрүүлсэн байх;

<b>хамтын ажиллагаа</b>	хөгжүүлэн ахиц гарсан байх;  -Цэцэрлэгийн мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хамтран ажилласан байх;	хөгжүүлэн ахиц гарсан байх;  -Цэцэрлэгийн мэргэжлийн багш нарын бүлгийг чиглүүлэн, багшид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, үр дүнг тооцсон байх;	-Мэргэжлийн багш нарын 3-аас доошгүй бүлгийг чиглүүлэн, багшид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, үр дүнг тооцсон байх;
<b>Хамт олон, эцэг эх асран хамгаалагчийн сэтгэл ханамж</b>	-Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг эцэг, эх, асран хамгаалагчдад зориулан зохион байгуулж, үр дүнг тооцсон байх; -Багшийн ёс зүй, харилцааны чадварыг үнэлсэн хамт олны үнэлгээ -Хүүхэд хамгааллын болон цэцэрлэгийн дэмжлэгийн баг, гэр бүл, иргэн, байгууллагатай хамтран ажиллаж үр дүнд хүрсэн байх;		

3.2.2. Арга зүйчид мэргэшлийн зэрэг олгоход дараах тусгай шалгуурыг баримтална:

Шалгуур	Мэргэшлийн зэрэг		
	Заах аргач	Тэргүүлэх	Зөвлөх
<b>Хүүхдийн хөгжлийн ахиц</b>	-Цэцэрлэгийн хүүхдийн хөгжилд гарсан ахиц, өөрчлөлтийг тооцож, үр дүнд хүрсэн байх;  -Хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээг харгалзан хувилбарт арга зүйг боловсруулан, туршиж үр дүнд хүрсэн байх;		-Цэцэрлэгийн хүүхдийн хөгжилд гарсан ахиц, өөрчлөлтийг тооцож, үр дүнд хүрсэн байх;  -Хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээг харгалзан хувилбарт арга зүйг боловсруулан, үр дүнг түгээн дэлгэрүүлсэн байх;
<b>Багшийн мэргэжлийн хөгжил, хамтын ажиллагаа</b>	-Багш нарын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг тооцож, дэмжлэг үзүүлсэн байх;  -Сургалтын чанар, үр дүнг сайжруулах бүтээлч арга зүйг	-Багш нарын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг тооцож, дэмжлэг үзүүлсэн байх; -Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг орон нутгийн түвшинд	-Багш нарын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг тооцож, дэмжлэг үзүүлсэн байх;  -Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих



	<p>эзэмшиж, судлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;</p> <p>-Мэргэжлийн багш нарын бүлэг, хамтын ажиллагааг дэмжих сургалт, үйл ажиллагааг байгууллагын түвшинд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;</p>	<p>зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;</p> <p>-Мэргэжлийн багш нарын бүлгийн ажлыг чиглүүлэн, бүтээлч арга зүй туршлагыг түгээн дэлгэрүүлсэн байх;</p>	<p>сургалт, үйл ажиллагааг бусад аймаг, дүүрэг, орон нутгийн түвшинд зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;</p> <p>-Мэргэжлийн багш нарын бүлгийн ажлыг чиглүүлэн, 2-оос доошгүй бүтээлч арга зүй, туршлагыг түгээн дэлгэрүүлсэн байх;</p>
<p><b>Хамт олон, эцэг эх асран хамгаалагчийн сэтгэл ханамж</b></p>	<p>-Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг эцэг, эх, асран хамгаалагчдад зориулан зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;</p> <p>-Хүүхэд хамгаалал болон цэцэрлэгийн дэмжлэгийн баг, гэр бүл, иргэн, байгууллагатай хамтран ажиллаж үр дүнд хүрсэн байх;</p> <p>-Ажилтны ёс зүй, харилцааны чадварыг үнэлсэн хамт олны үнэлгээ;</p> <p>-Ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй байх.</p>		

3.2.3. Эрхлэгч нь Боловсрол ерөнхий хуулийн 33.2.2-т зааснаар Тэргүүлэх болон түүнээс дээш мэргэшлийн зэрэгтэй байх” бөгөөд мэргэшлийн зэрэг бататгах, “Тэргүүлэх, Зөвлөх” мэргэшлийн зэрэг олгоход дараах тусгай шалгуурыг баримтална:

Шалгуур	Мэргэшлийн зэрэг	
	Тэргүүлэх	Зөвлөх
<p><b>Тусгай шалгуур</b></p>		
<p><b>Боловсролын сургалтын байгууллагын менежмент</b></p>	<p>-Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг хамтын оролцоотой боловсруулан хэрэгжүүлсэн байх;</p> <p>-Байгууллагын өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүнд үндэслэн үйл ажиллагаагаа сайжруулан, ажлын үр дүнг тооцсон байх;</p> <p>-Багш, ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнд шинжилгээ хийж хэрэгцээнд нь тулгуурласан үр дүнтэй ажил зохион байгуулж, чанар, үр дүнг тооцсон байх;</p>	<p>-Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг хамтын оролцоотой боловсруулан хэрэгжүүлсэн байх;</p> <p>-Байгууллагын өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүнд үндэслэн үйл ажиллагаагаа сайжруулан, ажлын үр дүнг тооцсон байх;</p> <p>-Байгууллагын менежмент, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийн үр дүн, багш, ажилтны хөгжил,</p>

		нийгмийн баталгааг хангах чиглэлээр судалгаа хийж сургалт, үйл ажиллагааг 5-аас доошгүй удаа зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;
<b>Багшийн мэргэжлийн хөгжил, хамтын ажиллагаа</b>	<p>-Хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургах чиглэлээр багш нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн байх;</p> <p>-Багш нарын зөвлөл, мэргэжлийн багш нарын бүлгийн ажлыг чиглүүлэн, 2-оос доошгүй бүтээлч арга зүй, туршлагыг түгээн дэлгэрүүлсэн байх;</p> <p>-Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг орон нутгийн түвшинд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;</p>	<p>-Хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургах чиглэлээр багш нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн байх;</p> <p>-Багш нарын зөвлөл, мэргэжлийн багш нарын бүлгийн ажлыг чиглүүлэн, 3-аас доошгүй бүтээлч арга зүй, туршлагыг түгээн дэлгэрүүлсэн байх;</p> <p>-Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг үндэсний түвшинд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;</p>
<b>Сургалтын орчин</b>	<p>-Хүүхдийн хоол, хүнсний шим тэжээллэг байдал, эрүүл ахуй, технологийн горимыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын үр дүн;</p> <p>-Сургалтын байгууллагын орчинд багш, ажилтан, бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар авсан арга хэмжээ, үр дүн;</p> <p>-Цэцэрлэгийн сургалтын орчны стандартын шаардлага хангасан байдалд хамт олон, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоотой өөрийн үнэлгээ хийж, боловсролын үйлчилгээний чанар, үр дүнг тооцсон байх;</p>	
<b>Ёс зүй, манлайлал</b>	<p>-Удирдлагын манлайлах ур чадвар, харилцаа хандлага, ёс зүй, хариуцлагатай холбоотой үндэслэл, нотолгоо бүхий гомдол дээд шатны байгууллагуудад ирж, нотлогдоогүй байх;</p> <p>-Удирдах ажилтны ёс зүй, харилцааны чадварыг үнэлсэн хамт олны үнэлгээ;</p> <p>-Хүүхэд хамгаалал, дэмжлэгийн баг, гэр бүл, иргэн, байгууллагатай хамтран ажиллаж үр дүнд хүрсэн байх;</p>	



## **Дөрөв. Мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааны зохион байгуулалт**

4.1. Мэргэшлийн зэрэг авах (энэ журамд заасан нийтлэг болон тусгай шалгуурыг хангасан талаар журмын 4.2-т заасан) холбогдох материалыг жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор боловсролын мэдээллийн нэгдсэн системд цахимаар бүрдүүлэн холбогдох байгууллагад илгээнэ.

4.2. Багш, арга зүйч, эрхлэгч нь дараах материалыг боловсролын мэдээллийн нэгдсэн системд цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

4.2.1. Мэргэшлийн зэрэг олгох талаар гаргасан хүсэлт;

4.2.2. Хүсэлт гаргагчийн анкет;

4.2.3. Энэхүү журмын 3.2-т заасан ерөнхий шалгуур болон 3.2.1, 3.2.2, 3.2.3-т заасан тусгай шалгуур тус бүрийг хангасныг нотлох баримт, нотолгоо;

4.2.4. Мэргэшлийн зэрэгтэй тохиолдолд өмнөх мэргэшлийн зэргийн тушаал шийдвэр/үнэмлэхний хуулбар/;

4.2.5. Ажлын хэсгийн хурлын тэмдэглэл;

4.3. Мэргэшлийн зэргийн хүсэлтийг журамд заасан шалгуурын дагуу магадлан, дүгнэлт гаргах ажлын хэсгийг тухайн мэргэшлийн зэрэг олгох эрх бүхий албан тушаалтан томилно.

4.4. Ажлын хэсэг 3-9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд цэцэрлэгийн түвшинд арга зүйч, багшийн төлөөлөл, байгууллагын ёс зүйн хорооны төлөөлөл, орон нутаг, үндэсний түвшинд сургуулийн өмнөх боловсрол; гүйцэтгэлийн үнэлгээ; багш, удирдах ажилтны хөгжил хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, ёс зүйн хорооны төлөөлөл тус тус байна.

4.5. Ажлын хэсгийн гишүүн бүр магадлан дүгнэлт гаргах үйл ажиллагаанд оролцохын өмнө холбогдох хууль тогтоомжид заасны дагуу “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн эсэх тухай мэдэгдэл”-ийг бөглөнө.

4.6. Ажлын хэсэг дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.6.1. Багшийн ирүүлсэн материалд энэхүү журамд заасан шалгуур үзүүлэлт тус бүрээр хангаж буй эсэхийг нотлох баримтад үндэслэн магадлан хянаж, дүгнэлт гаргана.

4.6.2. Багш энэхүү журамд заасан шалгуурыг хангаж байгаа эсэх, мэргэшлийн зэрэг олгох, бататгах, хасах, хүчингүй болгохтой холбоотой дүгнэлтийг ажлын хэсгийн 90-ээс доошгүй хувийн оролцоотой дэмжсэн тохиолдолд дүгнэлтийг хүчинтэйд тооцно.

4.6.3. Шаардлагатай тохиолдолд багш, арга зүйч, эрхлэгч нь тухайн мэргэшлийн зэргийн шалгуурыг хангаж буй эсэхийг ажлын байранд нь очиж магадлан шалгаж болно.

4.6.4. Мэргэшлийн зэрэг олгох, бататгах, хүчингүй болгох тухай гаргасан дүгнэлтийг мэргэшлийн зэрэг олгох эрх бүхий албан тушаалтанд танилцуулж шийдвэрлүүлэх, боловсролын мэдээллийн системд баталгаажуулах ажлыг гүйцэтгэнэ.

4.6.5. *Цэцэрлэгийн ажлын хэсэг нь* багшийн цахимд байршсан баримт материалыг тухайн оны **04 дугаар сарын 01-ний дотор** энэхүү журамд

нийцүүлэн хянаж, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч, багш нарын зөвлөлд танилцуулна.

4.6.6. Цэцэрлэгийн ажлын хэсэг нь багш, арга зүйчид **“Заах аргач”** мэргэшлийн зэрэг олгох, бататгах, хүчингүй болгох талаар дүгнэлтийг эрхлэгчийн тушаалаар баталгаажуулан, гарсан шийдвэрийг тухайн оны **04 дүгээр сарын 15-ны дотор** боловсролын мэдээллийн нэгдсэн системд баталгаажуулна.

4.6.7. Цэцэрлэгийн ажлын хэсэг нь багш, арга зүйчид мэргэшлийн магадлан шалгасан дүгнэлтийг магадлан шалгаж, **“Тэргүүлэх”, “Зөвлөх”** тухайн оны **04 дугаар сарын 30-ны дотор** багтаан боловсролын мэдээллийн нэгдсэн системээр дараагийн шатны байгууллагад илгээнэ.

4.6.8. *Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагаас томилогдсон ажлын хэсэг нь* “Тэргүүлэх, “Зөвлөх” мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох талаар дүгнэлт гарган, тухайн оны 06 дугаар сарын 30-ны дотор боловсролын мэдээллийн нэгдсэн системд нэгтгэн баталгаажуулж, дараагийн шатанд илгээх ажлыг гүйцэтгэнэ.

4.6.9. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас томилогдсон ажлын хэсэг нь “Зөвлөх” мэргэшлийн зэргийн дүгнэлт, шийдвэрийг тухайн оны 10 дугаар сарын 01-ний дотор багтаан боловсролын мэдээллийн нэгдсэн системд байршуулна.

4.6.10. Ажлын хэсэг нь мэргэшлийн зэрэг олгосон, бататгасан, түдгэлзүүлсэн тухай шийдвэрийг хүсэлт гаргасан багшид мэдээллийн нэгдсэн системээр дамжуулан хүргэнэ.

4.7. Ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн “Заах аргач” мэргэшлийн зэрэг олгох тухай шийдвэрийг тухайн оны 6 дугаар сард багтаан цэцэрлэгийн эрхлэгч баталгаажуулна.

4.8. Ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн “Тэргүүлэх” мэргэшлийн зэрэг олгох тухай шийдвэрийг тухайн оны 7 дугаар сарын 01-ний өдөрт багтаан Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталгаажуулна.

4.9. “Зөвлөх” мэргэшлийн зэргийн шалгуур хангасан багш, арга зүйч, эрхлэгчид энэхүү журмын 4.4-д заасан ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн тухайн оны 10 дугаар сарын 01-ний дотор багтаан Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаал, шийдвэрээр баталгаажуулна.

4.10. Ажлын хэсгийн дүгнэлтээр “Тэргүүлэх”, “Зөвлөх” мэргэшлийн зэрэг шинээр олгох эсхүл бататгахад ерөнхий болон тусгай шалгуур хангаагүй буцаагдсан тохиолдолд боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын ажлын хэсэг өмнөх мэргэшлийн зэргийн шалгуурыг хангаж буй талаар дүгнэлт гарган тухайн оны 10 дугаар сард багтаан баталгаажуулж болно.



## **Тав. Мэргэшлийн зэргийн нэмэгдэл**

5.1. Цэцэрлэг болон Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь мэргэшлийн зэргийн нэмэгдэл авч буй болон шинээр мэргэшлийн зэргийн нэмэгдэлд шаардагдах зардлыг тооцож, дараа оны төсвийн төсөлд тусгана.

5.2. Багш, ажилтанд мэргэшлийн зэрэг олгох шийдвэрийн дагуу цэцэрлэг нь мэргэшлийн зэрэг ахиулсан, шинээр авсан багш удирдах ажилтанд мэргэшлийн зэргийн нэмэгдлийг дараа оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон хувь, хэмжээгээр тооцож олгоно.

5.3. Мэргэшлийн зэргийн шатлал ахиулсан багш, арга зүйч, эрхлэгчид энэ журмын 5.2-т заасан нэмэгдлийг авах хүртэл хугацаанд өмнөх мэргэшлийн зэргийн нэмэгдлийг олгоно.

### **Зургаа. Мэргэшлийн зэрэг хэвээр хадгалах, хүчингүй болгох**

6.1. Багш, арга зүйч, эрхлэгчид олгосон мэргэшлийн зэрэг дараах тохиолдолд хэвээр хадгалагдана.

6.1.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 106.1-д заасны дагуу жирэмсний, амаржсаны хүүхэд асрах чөлөөтэй тохиолдолд 3 жил;

6.1.2. Ажлаас үндэслэлгүйгээр халагдсаныг шүүхээр эгүүлэн тогтоосон бол уг шалтгаанаар ажилгүй байсан хугацааг;

6.1.3. Ажил олгогчийн зөвшөөрлөөр гадаад улсад мэргэжил дээшлүүлэх, магистр, докторын сургалтад хамрагдаж байгаа тохиолдолд 3 жил;

6.1.4. Цэргийн жинхэнэ албанд татагдсан тохиолдолд 1 жил;

6.1.5. Боловсролын салбарын мэргэжил, арга зүйн байгууллагад албан тушаал дэвшиж, шилжиж, сэлгэн ажилласан тохиолдолд 2 жил;

6.1.6. Удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрээр 2 хүртэлх жил өөр ажил үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд тухайн хугацаанд;

6.1.7. “Тэргүүлэх” мэргэшлийн зэргийг гурав, “Зөвлөх” мэргэшлийн зэргийг хоёр удаа бататгасан багш, арга зүйч, эрхлэгчийг өндөр насны тэтгэврээ тогтоолгох хүртэл хугацаанд хүчинтэйд тооцон хэвээр хадгална.

6.1.8. Багш, удирдах ажилтан нь ижил төстэй сургалтын байгууллагын хооронд шилжиж ажилласан бол тухайн мэргэшлийн зэргийг хүчинтэйд тооцож, хэвээр хадгална.

6.2. Мэргэшлийн зэрэг олгосон байгууллагын тушаалаар дараах тохиолдолд мэргэшлийн зэргийг хүчингүй болгоно.

6.2.1. Энэхүү журмын 6.2-т зааснаас бусад тохиолдолд мэргэшлийн зэргийг хугацаандаа бататгаагүй;

6.2.2. Тухайн мэргэшлийн зэргийн шалгуурыг хангаагүй;

- 6.2.3. Хүүхдийн эрхийг ноцтой зөрчсөн нь баримт нотолгоотой, эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэрээр нотлогдсон;
- 6.2.4. Мэргэшлийн зэрэг олгох, бататгах, шатлал ахиулах хүсэлт гаргахдаа хуурамч баримт бүрдүүлсэн, худал мэдүүлсэн тохиолдолд мэргэшлийн зэргийг тус тус хасаж хүчингүйд тооцно.
- 6.2.5. Орон нутгийн боловсролын газар нь заах аргач мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагаа, Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь тэргүүлэх мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагаа, Зөвлөх мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагаанд Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана. Зөрчил гарсан тохиолдолд шийдвэр гаргасан этгээдэд хариуцлага тооцож, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

### **Долоо. Мэргэшлийн зэргийн мэдээллийг бүртгэх, хөтлөх**

7.1. Боловсролын салбарын мэдээллийн систем нь сургуулийн өмнөх боловсролын салбарын мэргэшлийн зэрэгтэй багш, арга зүйч, эрхлэгчийн мэдээлэл, энэ журмын 4.1.1-т заасан мэдээлэл, мэдээллийг байршуулах талбар, мэргэшлийн зэрэг олгох, бататгах, хүчингүй болгох үйл ажиллагааг зохион байгуулах зэргийн боловсролын нэгдсэн бүртгэл мэдээллийн цахим санд бүртгэнэ. .

7.2. Мэргэшлийн зэргийн бүртгэл мэдээллийн цахим сан нь мэргэшлийн зэрэгтэй багш, арга зүйч, эрхлэгчийн мэдээллийг байршил, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, байгууллага, цэцэрлэг, албан тушаал, ажилласан жил зэргээр гүйцэтгэлийн үнэлгээний түвшин, мэргэшлийн зэргийн нэмэгдлийн дүнгээр нэгтгэж, бүлэглэж харах боломжтой, ил тод, нээлттэй байна.

7.3. Мэргэшлийн зэргийн бүртгэл мэдээллийн санг цэцэрлэгийн түвшинд эрхлэгч/арга зүйч, орон нутгийн түвшинд сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан арга зүйч/мэргэжилтэн, Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад холбогдох мэргэжилтэн тус тус бүртгэж, хөтөлнө.

7.4. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэргэшлийн зэрэг олгох, бататгах, хүчингүй болгох үйл ажиллагааг боловсролын мэдээллийн нэгдсэн системд тулгуурлан арга зүйн удирдлагаар хангаж, 7.2-д заасан мэдээллийг жил бүрийн 2 дугаар сард багтаан Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

### **Найм. Бусад**

8.1. Мэргэшлийн зэрэг олгох, бататгах үйл ажиллагаанд энэхүү журмын 1.2-ыг зөрчсөн, 3.2-д заасан шалгуур хангаагүй багш, аргазүйч, эрхлэгчид мэргэшлийн зэрэг олгосон, шийдвэрийн баталгаажилт хууль бус гэж үзсэн тохиолдолд



мэргэшлийн зэрэг олгох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд үндэслэл, баримт нотолгооны хамт бичгээр өргөдөл, гомдол гаргаж болно.

8.2. Өргөдөл, гомдлыг хүлээн авсан байгууллага нь хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэж, дурдсан асуудлыг дагуу хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох арга хэмжээ авсныг мэдэгдэж, хариу өгнө.

8.3. Ажлын хэсгийн гишүүн нь багшийн мэдээллийг магадлан шалгах, үнэлгээ дүгнэлт гаргах, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох шийдвэртэй холбоотой ажлын явц, албан мэдээллийг бусдад тараах, нийтэд мэдэгдэхийг хориглоно.

8.4. Мэргэшлийн зэрэг олгох, бататгах, шатлал ахиулах, хүчингүй болгох үйл ажиллагааны бүрдүүлсэн баримт бичиг, ажлын хэсгийн дүгнэлт, санал, мэргэшлийн зэрэг олгох шийдвэрийг эрх бүхий байгууллага нь “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль”-ийн дагуу баримт үүсгэнэ.

8.5. Мэргэшлийн зэрэг олгох эрх бүхий албан тушаалтан нь ажлын хэсгийн гаргасан санал, дүгнэлтийг баримт бичгийн бүрдэл хангуулахаар нэг удаа буцааж болох бөгөөд үүнээс бусад тохиолдолд үндэслэлгүйгээр буцаах, ажлын хэсгийн санал дүгнэлтээр шалгуур хангасан багш ажилтанд мэргэшлийн зэрэг олгохоос татгалзах, шалгуур хангаагүй багш, ажилтанд мэргэшлийн зэрэг олгохыг хориглоно.

8.6. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.